




ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

“ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА”
АЯН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ



Авлимын эсрэг

...**НЭГДЭЭ**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА АЯНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.10.13

Мандалговь хот



Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 01/1691 дугаартай захирамжаар “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аяныг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тус аяныг Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газраас эхлүүлэхээр гардуулан өгч нэг байгууллагад 8 хоногийн хугацаатайгаар календарчилсан хуваарийн дагуу байгууллагуудаар аялуулан ажиллаж байна. Хуваарийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 04-13-ныг хүртэл “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа аян”-ыг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулж ажиллалаа. Аяны хүрээнд Авлигатай тэмцэх газрын “Ботгохон” хөтөлбөртэй хамтран бүтээсэн “Шударга тоглоцгооё” <https://fb.watch/nC3wPf3K19/> дууг хүүхэд, багачууддаа зориулан албан ёсны фейсбүүк хаягаараа дамжуулж, Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Чи ганцаараа биш” нөлөөллийн арга хэмжээнд Авлигын тухай ойлголт, Авлигын гэмт хэргийн талаар 6-12 дугаар ангийн нийт 540 охидод мэдээллийг түгээж ажиллалаа.

<https://www.facebook.com/photo/?fbid=829882375498987&set=pcb829882758832282>

Иргэд, олон нийтэд “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэхийг уриалсан эх мэдээлэл бэлтгэн танилцуулж, “Шинэ үе Авлигыг тэвчихгүй”, “Үгүй гэж хэлээд өөрчилье”, “Авлигын эсрэг нэгдье” уриалгыг Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, албан хаагчид, хүүхэд, багачууд нийтэд уриалсан видеог байгууллагын фейсбүүкт байршуулж 100 хандалт, 10 шейрийг авлаа.

<https://fb.watch/nDn4OHXY3d/8>, <https://fb.watch/nDn63c3u0H/>.

“Авлигыг мэдээлэх утас 110” наалтыг байгууллагын бүх албан хаагчдад өгч, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор байгууллагын “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбар болон цахим хаягтаа 2 зурагт хуудсыг бэлтгэн байршуулаа.





ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН М.ЗОЛБОО
ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЗОРИГ

